ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
АРВАЙХЭЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 07 сарын 02 өдөр Дугаар А/119 Арвайхээр сум

Мал, амьтанд үзлэг, оношилгоо хийх зөөврийн өнгөт эхо аппарат нийлүүлэх гүйцэтгэгч сонгон шалгаруулах үнэлгээний хороо байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын орон нутгийн төсвийн хөрөнгөөр мал, амьтанд үзлэг, оношилгоо хийх зөөврийн өнгөт эхо аппарат нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны дарга: Б.Доржсүрэн (төсөв, төрийн сангийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: Г.Энх-Оюун (Мал аж ахуйн асуудал хариуцсан мэргэжилтэн)
Гишүүн:Ө.Золбаяр (Бэлчээр газар тариалангийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомж, заавар журмын дагуу үр дүнтэй зохион байгуулахыг үнэлгээний хорооны дарга (Б.Доржсүрэн), гишүүдэд тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА Б.ГАНБАТ

D:\2024\Alban bichig\Zahiramj- 2024.docx

62241283